



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН

2017 Э-сонин

ХАГАС ЖИЛ

51-р дугаар





Зах зээлийн тойм

Зах зээлийн үнэлгээ

/2017.06.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр **125**

2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/ **512,255,005,690.24**

Хувьцаа 12,234,874,116.24 Тэрбум ₮

Засгийн газрын үнэт цаас /анхдагч/ 433,896,834,204.00

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/ 60,123,297,370.00

Компанийн бонд /анхдагч/ 6,000,000,000.00

Компанийн бонд /хоёрдогч/

3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг **50,916,400**

Хувьцаа 45,543,400


Засгийн газрын үнэт цаас /анхдагч/ 4,696,035

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/ 616,965

Компанийн бонд /анхдагч/ 60,000



Компанийн бонд /хоёрдогч/

4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо **13,351**



MSE ALL индекс

TOP-20 индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

Гишүүн үнэт цаасны компани

1. Нийт компанийн тоо	220
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	189
I ангилал	7
II ангилал	45
III ангилал	167
Ангилалдаагүй	1

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	58
Брокер, Дилер	58
Андеррайтер	24
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



Үнэт цаасны зах зээл

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

/2017.01.02-2017.06.30/

Сим бол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/
		Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Тоо ширхэг	Үнийн дүн	
1	Новел инвестмент ХХК	1,164,856	106,637,929,095	1,000,027	89,840,096,788	196,478,025,883
2	БиДиСек ХК	30,380,129	137,350,150,124	29,385,478	5,782,697,446	143,132,847,571
3	Мирэ Эссет Секьюритис Монгол	1,103,668	102,131,892,292	295,828	27,044,716,723	129,176,609,015
4	Тэнгэр капитал ХХК	614,727	56,539,598,912	6,338	125,242,400	56,664,841,312
5	Голомт капитал ХХК	3,246,475	46,232,034,586	3,000,945	4,023,030,864	50,255,065,450
6	Ард капитал групп ХХК	715,759	20,820,482,407	399,386	238,168,419	21,058,650,826
7	Ти Ди Би Капитал ХХК	690,172	12,522,041,091	388,393	-	12,522,041,091
8	Стандарт инвестмент ХХК	4,175,160	6,155,274,112	4,608,056	873,431,660	7,028,705,772
9	Ард секюритиз ХХК	1,276,291	4,272,217,565	1,057,560	563,792,261	4,836,009,826
10	Гаүли ХХК	708,713	3,595,457,659	1,073,562	563,558,897	4,159,016,555
11	Эм Ай Би Жи ХХК	804,090	2,348,773,708	52,502	37,248,713	2,386,022,421
12	Лайфтайм инвестмент ХХК	1,922,065	884,446,805	1,920,448	879,924,317	1,764,371,122
13	Монсек ХХК	202,679	1,602,850,920	106,435	120,684,013	1,723,534,933
14	Нэйшнл сэкюритис ХХК	14,064	1,174,079,993	41,205	18,645,611	1,192,725,604
15	Азиа Пасифик секьюритис ХХК	44,712	935,121,081	45,355	40,321,600	975,442,681

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2017.01.02-2017.06.30

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	TTL	ТАВАН ТОЛГОЙ	1,601,398	2,298,282,489.00	5780	2500	4,795.00	2107	78.39
2	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	15,660,708	845,974,274.72	67.9	48	63.93	3.92	6.53
3	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	1,865,694	696,763,652.57	414	312	388.00	55.87	16.82
4	GOV	ГОВЬ	50,161	629,740,225.00	15050	9550	13,050.00	3410	35.37
5	MMX	МАХИМПЕКС	546,922	592,389,535.00	2799	2300	2,400.00	-350	-12.73
6	HGN	ХӨХ ГАН	10,688,823	575,918,585.08	100	53.55	99.90	32.95	49.22
7	APU	АПУ	1,804,693	574,194,861.49	380	270	290.03	-89.97	-23.68
8	UYN	МОНГОЛ САВХИ	872,415	489,149,620.76	900	580	753.00	-146	-16.24
9	BNG	БАЯНГОЛ ЗБ	10,666	408,110,720.00	42400	35000	36,060.00	-5940	-14.14
10	MRX	МЕРЕКС	3,935,655	275,233,829.30	90	53.55	53.55	-6.45	-10.75
11	TCK	ТАЛХ ЧИХЭР	12,138	252,240,250.00	23300	18130	21,700.00	3570	19.69
12	BDS	БИДИСЕК	1,090,975	150,379,386.00	1490	1190	1,190.00	-318	-21.09
13	EER	АРИГ ГАЛ	64,103	143,873,246.00	2550	2103	2,451.00	151	6.57
14	MCH	МОН.ЦАХИЛГААН	231,182	127,199,280.50	700	501.1	504.25	-272.75	-35.10
15	NEH	ДАРХАН НЭХИЙ	5,257	104,678,710.00	23200	19100	20,500.00	1000	5.13
16	SUU	СҮҮ	773,035	99,602,360.81	140	122	137.07	9.06	7.08
17	ADL	АДУУНЧУЛУУН	41,052	86,687,870.00	2809	1705	2,101.00	301	16.72
18	MIE	МАТЕРИАЛИМПЕКС	9,156	76,047,480.00	9200	7800	8,000.00	-1000	-11.11
19	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	1,536	73,236,810.00	60000	41000	44,080.00	-1320	-2.91
20	SUN	ЕВРОАЗИЯ КАПИТАЛ	2,198,139	70,595,828.77	56.22	27.97	56.22	31.89	131.07



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2017.01.02-2017.06.30/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /төгрөг/	Өөрчлөлт /хувиар/
			2017-01-02	2017-06-30		
1	АЛТАНДУУЛГА	180	874.17	2,324.00	1,449.83	165.85%
2	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	2,198,139	24.33	56.22	31.89	131.07%
3	ТАВАН ТОЛГОЙ	1,601,398	2,688.00	4,795.00	2,107.00	78.39%
4	ЗООС ГОЁЛ	75	146,000.00	246,600.00	100,600.00	68.90%
5	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	880	1,450.00	2,250.00	800.00	55.17%
6	МОНГОЛ АЛТ	60	4,100.00	6,170.00	2,070.00	50.49%
7	ХӨХ ГАН	10,688,823	66.95	99.90	32.95	49.22%
8	БҮТЭЭЛЧ ҮЙЛС	340	901.00	1,300.00	399.00	44.28%
9	ХИШИГ УУЛ	2,207	850.11	1,200.00	349.89	41.16%
10	УЛААНБААТАР ХИВС	597	9,020.00	12,490.00	3,470.00	38.47%
11	ГОВЬ	50,161	9,640.00	13,050.00	3,410.00	35.37%
12	ГУТАЛ	3,137	12,600.00	17,010.00	4,410.00	35.00%
13	ДАВААНБУЛАГ	202	150.00	198.37	48.37	32.25%
14	ТЕХНИКИМПОРТ	4	6,125.00	8,090.00	1,965.00	32.08%
15	ЭРДЭНЭТ ХҮНС	130	1,330.00	1,750.00	420.00	31.58%
16	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ	15,040	151.00	195.50	44.50	29.47%
17	БАЯНТЭЭГ	490	9,000.00	11,500.00	2,500.00	27.78%
18	БӨӨНИЙ ХУДАЛДАА	1,706	400.00	500.00	100.00	25.00%
19	ХАРХОРИН	1,247	1,610.00	1,991.00	381.00	23.66%
20	ТАЛХ ЧИХЭР	12,138	18,130.00	21,700.00	3,570.00	19.69%

Ханшийн бууралттай хувьцаа

/2017.01.02-2017.06.30/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт Төгрөг/	Өөрчлөлт /хувиар/
			2017-01-02	2017-06-30		
1	СОР	404	1,899.00	860.00	-1,039.00	-54.71
2	ТӨМРИЙН ЗАВОД	2,211	15,500.00	7,800.00	-7,700.00	-49.68
3	ХАЙ БИ ОЙЛ	260,874	198.00	100.00	-98.00	-49.49
4	ЕВРОФЁ АЗИА	9,745	1,800.00	943.75	-856.25	-47.57
5	СТАНДАРТ НООС	915	735.00	449.00	-286.00	-38.91
6	ИХ БАРИЛГА	730	4,000.00	2,500.00	-1,500.00	-37.50
7	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	231,182	777.00	504.25	-272.75	-35.10
8	ДАРХАН ХӨВӨН	758	26,000.00	18,000.00	-8,000.00	-30.77
9	ТҮШИГ УУЛ	3,621	414.00	292.11	-121.89	-29.44
10	ГАН ХЭРЛЭН	152	4,100.00	2,903.00	-1,197.00	-29.20
11	БАЯЛАГ НАЛАЙХ	780	235.00	170.00	-65.00	-27.66
12	РЕМИКОН	1,252,237	62.00	45.26	-16.74	-27.00
13	АВТОЗАМ АРХАНГАЙ	88	6,000.00	4,500.00	-1,500.00	-25.00
14	ХЭРЛЭН ХИВС	16,760	125.00	94.00	-31.00	-24.80
15	ЧАЦАРГАНА	2,912	945.00	720.00	-225.00	-23.81



"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК ТОРОНТОГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР

Канадын Торонто хотноо 2017 оны 3 сарын 5-8 өдрүүдэд зохион байгуулагдсан Канадын хайгуулч, олборлогчдын холбоо (PDAC)-ны чуулга уулзалтын үеэр Монголын төлөөлөгчдийг Торонтогийн хөрөнгийн биржийн Олон улсын бизнесийн хөгжлийн газрын захирал Роберт Петерман, Үнэт цаасны зах зээлийн газрын захирал Унгад Чадда нар хүлээн авч уулзлаа.

Уулзалтад Монгол Улсыг төлөөлж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, УИХ-ын гишүүн А.Ундраа, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай болон бусад төлөөлөгчид оролцов.

Уулзалтын үр дүнд МХБ болон Торонтогийн хөрөнгийн бирж давхар бүртгэлийн үйл ажиллагааг эхлүүлэх чиглэлд хамтран ажиллахаар болжээ. Манай улсын хувьд Үнэт цаасны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2013 онд батлагдсанаар давхар бүртгэлийн үйл ажиллагаа эхлүүлэх хууль эрхзүйн орчин нээгдсэн хэдий ч, өнөөдрийн байдлаар энэхүү боломжийг ашиглаж давхар бүртгэгдсэн компани байхгүй байна.

Торонтогийн хөрөнгийн бирж нь зах зээлийн үнэлгээгээрээ дэлхийд 9 дүгээрт бичигддэг, нийт 3,278 хувьцаат компани бүртгэгдсэн томоохон бирж бөгөөд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын бүртгэлээр дэлхийд тэргүүлдэг болно. 2015 онд гэхэд Торонтогийн хөрөнгийн биржид нийт 57.7 тэрбум канад долларын санхүүжилт босгосон байдаг бөгөөд олон улсын хэмжээнд уул уурхайн нийт санхүүжилтийн талаас илүү хувь нь тус биржээр

дамжин санхүүжигдсэн биржид бүртгэлтэй Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг "Erdene Resource Development Corporation", "South Gobi Resources", "Turquoise Hill Resources" зэрэг 11 компани бий аж. Дээрх хамтын ажиллагаа эхэлснээр эдгээр компаниудыг МХБ-д давхар бүртгэн, дотоодын хөрөнгө оруулагчдад үнэт цаасыг санал болгох бүрэн боломжтой юм.

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК- ИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АРИЛЖАА ТҮҮХЭН ДЭЭД ХЭМЖЭЭНД ХҮРЛЭЭ

2017 оны эхний хагас жилийн байдлаар Монголын хөрөнгийн биржээр нийт 512.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 4.5 дахин өсч, түүхэн хугацаанд хамгийн өндөр үнийн дүнтэй арилжаа хийгдсэн жил болж байна. 2014-2017 оны үнэт цаасны арилжааны дүнг доорх хүснэгтээр харуулав.

№	Огноо	Үнэт цаасны арилжааны дүн /тэрбум төгрөг/
1	2014.12.31	60.3
2	2015.12.31	546.4
3	2016.12.31	348.7
4	2017.06.30	512.3



"СҮҮ БОНД" МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР АМЖИЛТТАЙ АРИЛЖИГДЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч компани болох Монгол Улсын хүнсний ууган үйлдвэр “Сүү” ХК-ийн хувьцаагаар баталгаажсан 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нэг жилийн хугацаатай, жилийн 17.5 хувийн хүүтэй өрийн хэрэгсэл “Сүү Бонд” нь 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэйгээр арилжаалагдаж, нийт 6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ.

Тус өрийн хэрэгслийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн А/108 тоот тушаал болон Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 129 тоот тогтоолоор үнэт цаасны бүртгэлд бүртгэж, олон нийтэд арилжаалахыг зөвшөөрсөн билээ.

Өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгон амжилттай арилжаалахад Монголын хөрөнгийн биржийн гишүүн болох “Голомт капитал ҮЦК” ХХК нь үндсэн андеррайтераар, “Ард капитал групп ҮЦК” ХХК, “Тэнгэр капитал ҮЦК” ХХК нар нь туслах андеррайтераар тус тус ажилласан бөгөөд 2017 оны 6 дугаар сарын 23-наас 29-ний өдрүүдэд үнэт цаасны сурталчилгааг явуулж, хөрөнгө оруулагчдаас захиалгыг хүлээн авах ажлыг зохион байгуулж, 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлсэн.

Ийнхүү Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжаанд “Сүү Бонд”-ын нийт 67,547 ширхэг буюу 6,754,700,000 төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авах захиалга бүртгэгдсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс 13%-аар давж, анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлт эхний өдөртөө дууссан нь Монголын хөрөнгийн зах зээлд компанийн өрийн хэрэгсэл эрэлт өндөртэй байгааг харуулж байгаа төдийгүй Монголын хөрөнгө оруулалтын орчин сайжирч байгааг илтгэж байгаа юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ФРОНТИЕР ЗАХ ЗЭЭЛИЙН АЖИГЛАЛТЫН ЖАГСААЛТАД ҮЛДЭЭХ АСУУДЛААР FTSE RUSSELL КОМПАНИТАЙ УУЛЗАЛТ ХИЙВ.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Н.Мандуул, Гүйцэтгэх захирал Х.Алтай нар Их Британийн Лондон хотноо зохион байгуулагдсан Монгол Лондонгийн Бизнес Форумын үеэр, олон улсын индексийн тооцоо судалгаагаар тэргүүлэгч FTSE Russell-ийн төлөөлөгчид болох Засаглал, бодлогын газрын дарга Жоти Рана, Зөвлөлийн нарийн бичгийн дарга Жанет Камберпач болон Зөвлөлийн нарийн бичгийн даргын орлогч Ракеш Хира нартай уулзлаа.

Монголын хөрөнгийн зах зээлийг FTSE Russell компаниас Фронттиер буюу “Хөгжиж буй” зах зээлийн ангилалд багтах боломжтой хэмээн үзэж, 2012 онд ажиглалтын жагсаалтад оруулсан хэдий ч зах зээлийн дэд бүтцийн зарим зайлшгүй чухал асуудлуудыг шийдэх чиглэлээр дорвитой ахиц дэвшил гарахгүй байгаагаас манай улсыг ажиглалтын жагсаалтаас хасах нөхцөл байдал үүсээд байгаа тухай өмнө мэдээлсэн билээ.

Фронттиер зах зээлд багтахад тулгарч буй гол хүндрэлүүд болох үнэт цаасны төлбөр тооцооны дараа төлбөрт системд шилжих, DVP буюу “төлбөрийн эсрэг нийлүүлэлт” зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр манай байгууллагаас зах зээлийн бусад оролцогчид болох “АТТ” ХХК, “ҮЦТХТ” ХХК, ҮЦАЭХ зэрэг байгууллагуудтай хамтран ажлын хэсэг байгуулж, төлбөр тооцооны T+3 горимонд эргэн шилжих болон холбогдох бүх арга хэмжээг авч ажиллаж байна.

FTSE Russell компанийн Зах зээлийн үнэлгээний зөвлөлийн хурал нь энэ оны 9 дүгээр сард зохион байгуулагдах бөгөөд манай улсыг ажиглалтын жагсаалтад хэвээр үлдээх боломж олгохыг хүсэхийн хамтад, зах зээлийн шалгуурыг хангах чиглэлээр цаашид хийгдэх ажлын төлөвлөгөө хүргүүлж, хэрэгжилтийн явцыг тухай бүр тайлагнаж ажиллахаа мэдэгдэв.



ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛСЫН ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЯАМНЫ САЙД МАРК ГАРНИЕ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ЗОЧИЛОО

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Олон Улсын Худалдааны Яамны Сайд Марк Гарние Монголын хөрөнгийн биржид зочилж Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн 5442 дахь арилжааг нээж, цан цохилоо.

Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай хөрөнгийн биржийн бодлого, үйл ажиллагаа, Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдлын талаар мэдээлэл өгөв. Ноён Марк Гарние улс төрд орохоосоо өмнө хөрөнгө оруулалтын банкны хөгжиж буй зах зээлээр мэргэшин ажиллаж байснаа дурсаж цаашид хоёр улсын биржүүдийн хамтын ажиллагаа болон Их Британийн хөрөнгө оруулалтын сангуудыг Монгол улсад хөрөнгө оруулах чиглэлд дэмжин ажиллахаа илэрхийллээ.

Дашрамд дурдахад ноён Марк Гарние нь Лондонгийн хөрөнгийн биржийн зүгээс Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх ажилд өөрийн дадлага туршлагаас хуваалцан хамтран ажиллаж байсан юм.

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА /ЖАЙКА/- ЫН ТӨЛӨӨЛӨЛ АРИЛЖААНЫ НЭЭЛТ ХИЙЛЭЭ

Монгол Улсад IPO буюу анх удаа олон нийтэд үнэт цаасаа санал болгон санхүүжилт татах үйл ажиллагаа эхэлсэн өдрийг тохиолдуулан Санхүүгийн зохицуулах хороо /Хороо/-ны дэд дарга Д.Баярсайхан, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга, ноён Сато Мүцүми нар Хөрөнгийн биржийн 5482 дахь арилжааг эхлүүлж, хүндэтгэлийн цан цохилоо.

2005 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Монголын хөрөнгийн бирж дээр хийгдсэн "Монгол шилтгээн" ХК-ийн IPO амжилттай болсон бөгөөд түүнээс хойш нийт 15 компани олон нийтээс 97.6 тэрбум төгрөгийн санхүүжилт татаж чадсан байдаг.

Дашрамд дурдахад Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ нь "Монголын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх" төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрээнд Монгол Улсын хөрөнгийн зах зээлд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, олон улсын стандартыг нэвтрүүлэх, оролцогчдыг чадавхжуулах, зах зээл өндөр хөгжсөн орны туршлагыг судлах, хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг сайжруулах чиглэлээр ажилласан төслийн эхний үе шат ирэх долдугаар сард дуусах бөгөөд хоёр дахь үе шатыг 11 дүгээр сараас эхлүүлж дотоодын компаниудын IPO гаргах үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэлхийн нэр хүндтэй биржүүдэд давхар бүртгэл хийж, олон улсын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгох чиглэлд анхаарч ажиллахаар болсон байна.

“ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ХОНХ ЦОХИХ” АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО

Олон Улсын Санхүүгийн Корпораци /ОУСК/, МХБ, Компанийн Засаглалын Хөгжлийн Төв /КЗХТ/, Women Corporate Directors Монголын салбар, МҮХАҮТын дэргэдэх Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран “*Жендерийн тэгш байдлын төлөө хонх цохих*” ёслолын арга хэмжээг зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээг Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан бизнес болон тогтвортой хөгжилд жендерийн тэгш байдлын чухлыг олон нийтэд таниулах зорилгоор дэлхийн 40 гаруй Хөрөнгийн биржууд, НҮБ-ын Глобал Компакт, Тогтвортой Хөрөнгийн Биржийн санаачлага, НҮБ-ын Эмэгтэйчүүд санаачлага, ОУСК, Дэлхийн Биржүүдийн Холбоо, Women in ETF зэрэг байгууллагууд 3 дахь удаагаа зохион байгуулж байна.



БАГЦЫН АРИЛЖААНЫ ХАНШИЙН ХЭЛБЭЛЗЛИЙН ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООЛОО

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 10.11 дэхь заалт, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Арилжааны журам”-ын 33 дугаар зүйлийн 1 дэхь заалтыг тус тус үндэслэн гаргасан Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн А95 тоот тушаалаар багцын арилжааны ханшийн хэлбэлзлийн дээд хязгаарыг өмнөх өдрийн хаалтын ханшаас ± 15.0 хувь байхаар тогтоолоо.

Энэхүү багцын арилжааны ханшийн хэлбэлзлийн хязгаарыг 2017 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахаар боллоо.

“ЗООС ГОЁЛ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 77 тоот албан шаардлагаар “Зоос гоёл” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн түр зогсоолоо.

“ЕВРОФЁ АЗИА” ХК-ИЙН АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Еврофё Азия” ХК-нд газар дээрх хяналт шалгалт хийж байгаатай холбоотойгоор гаргасан Улсын байцаагчийн 2017 оны 5 дугаар сарын 04-ны өдрийн 66 тоот албан шаардлагыг үндэслэн хувьцааны арилжааг түр зогсоолоо.

“УУЖИМ ХАНГАЙ” ХК-ИЙН АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын байцаагчийн 2017 оны 4 дугаар сарын 11-ны өдрийн 51 тоот албан шаардлагыг үндэслэн “Уужим хангай” ХК-ийн хувьцааны арилжааг түр зогсоолоо.

ТОР-20 ИНДЕКСИЙН САГС ШИНЭЧЛЭГДЛЭЭ

Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын дагуу ТОП-20 индексийн багцыг 2017 оны эхний хагас жилд бүрдүүлэх үнэт цааснуудыг шалгаруулж, сагсыг шинэчлэв.

2016 оны сүүлийн хагас жилийн үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг шинэчлэхэд өмнөх сагсанд багтаж байсан 17 компани хэвээр үлдэж, “Женко тур бюро”, “Монголын Цахилгаан Холбоо”, “Мик холдинг” ХК-иуд хасагдаж, шинээр “Адуунчулуун”, “Хөх ган”, “Гермес центр” ХК-иуд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлэв.

“АТАР ӨРГӨӨ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

“Атар өргөө” ХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийсэн “Фискал аудит” ХХК-ийн зөвлөмж, тус компанийн хүсэлтийг үндэслэн гаргасан СЗХ-ны улсын байцаагчийн 2017 оны 2 сарын 24 өдрийн №15 тоот албан шаардлагаар “Атар өргөө” ХХК-ийн үнэт цаасны арилжааг түр хугацаагаар зогсоолоо.

НЭР БҮХИЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Компанийн тухай хуулийн 83.1 дүгээр заалт, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн компанийн дүрмийн 8.10.11-р заалт, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 24.8 дугаар заалтыг тус тус үндэслэн “Баянтолгой” ХК, “Гантөмөрт” ХК, “Завхан тээх” ХК, “Завхан тээвэр” ХК, “Монгол эсгий эсгий гутал” ХК, “Оргил Говь-алтай” ХК, “Улиастай тэгш” ХК гэх 7 компанийг бүртгэлээс хаслаа.



НЭР БҮХИЙ 52 ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТУЗ БҮРЭН ЭРХГҮЙ БОЛЛОО

Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаат компани /ХК/-ийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /ХЭЭХ/-ыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу жил бүрийн тавдугаар сарын 1-ний өдрөөс өмнө зарлан хуралдуулах үүрэгтэй. Хэрэв энэ хугацаанд ХЭЭХ-аа зарлан хуралдуулаагүй бол ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал /ХЭЭБХ/-ыг зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрхгүй болдог.

Одоог болтол буюу хуульд заасан хугацаанд дор нэр дурдсан 52 компани ХЭХ-аа зарлан хуралдуулаагүй тул хувьцаа эзэмшигчдийн хурал зарлахаас өөр ямарваа шийдвэр гаргах, компанийн үйл ажиллагааг удирдах эрхгүй болсныг Санхүүгийн зохицуулах хорооноос мэдэгдлээ.

1	АР ТАРХИ	19	ДОРНОД	37	СЭЛЭНГЭ СҮРЭГ
2	АВТОЗАМ	20	ДУЛААН ШАРЫН ГОЛ	38	ТӨВ УС
3	АГРОТЕХИМПЕК С	21	ЕВРОФЁ АЗИА	39	УЛААН САН
4	АЖЛЫН ХУВЦАС	22	ЖИНСТ	40	УЛИАСТАЙ ТЭГШ
5	АЛМААС	23	ИХ БАРИЛГА	41	ХАНГАЛ
6	АР БАЯНХАНГАЙ	24	ИХ НУУР	42	ХАРГИА
7	АСБИ	25	ИХ ҮҮСГЭЛ	43	ХАРШИЙН ГЭГЭЭ
8	БАЯЛАГ НАЛАЙХ	26	МОНАСАР	44	ХӨДӨӨГИЙН ТЭЭВЭР
9	БАЯЛАГ ШАРЫН ГОЛ	27	МОННООС	45	ХУРТАЙ
10	БАЯНТАЛБАЙ	28	МӨНХ ЖИМ	46	ХҮНС АРХАНГАЙ
11	БАЯНТООРОЙ	29	МҮДИКС	47	ХЭРЛЭН ХИВС
12	БИНСЭ/БАЯНХАЙРХАН	30	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	48	ЧАНДМАНЬ ДУНДГОВЬ
13	БОРООГИЙН ҮЙЛДВЭР	31	НОМИН ХИШИГ	49	ЧАНДМАНЬ УУЛ
14	БҮТЭЭЛ	32	ОРГИЛ ГОВЬ-АЛТАЙ	50	ШИМ
15	ГАНТӨМӨРТ	33	ӨВ УСЖУУЛАГЧ	51	ЭРДЭНЭТ ЗАНДАН
16	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС	34	ӨЛЗИЙ ДУНДГОВЬ	52	ЭСГИЙ ГУТАЛ
17	ГОВИЙН ӨНДӨР	35	ӨРГӨН ХЭРЭГЛЭЭ		
18	ГОНИР	36	СЭЛЭНГЭ ИМПЕКС		

БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУДЫН ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ БОЛЛОО

Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалтыг 2017 оны 5 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Тус сургалтанд 70 гаруй компани оролцсон бөгөөд Хөрөнгийн зах зээлийн нөөц боломж, Үнэт цаас гаргагчдын үүрэг, түүний хэрэгжилт, цаашид анхаарах асуудлуудын талаар МХБ-ээс мэдээлэл өгч, санал солилцлоо. Мөн “Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх тухай заавар”-ын шинэчилсэн найруулгыг танилцуулж, хэрхэн дагаж мөрдөх талаар арга зүйн зөвлөгөө өглөө.

Сургалтын үеэр хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг зохих шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэн хууль, тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар биелүүлэн ажиллаж байгаа “Гермес центр” ХК, “Монгол шуудан” ХК, “Тахь ко” ХК, “Шарын гол” ХК-иудын ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг “ОНЫ ШИЛДЭГ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА” -аар шалгаруулж өргөмжлөл олгов.

“БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУДААС ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ ЗААВАР” ШИНЭЧЛЭГДЛЭЭ

Компанийн тухай хуулийн 83.1 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Компанийн дүрмийн 8.1, 8.10.9, 8.10.11, дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журмын 4.12 заалтыг үндэслэн гаргасан МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сар 4-ний өдрийн А/79 тоот тушаалаар “Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар” шинэчлэн батлагдлаа.



ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖИЛИЙН ХУРААМЖИЙГ ХӨНГӨЛЛӨӨ

Монгол Улсын Компанийн хуулийн 83.1 зүйл, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 8.10.11 заалт, гишүүнчлэлийн журмын 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн гаргасан Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын А/19 тоот тушаалын дагуу 2016 онд хийгдсэн арилжааны үнийн дүнгээр тэргүүлэн, МХБ-ийн нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний гүйлгээг хийсэн нэр бүхий 5 гишүүн үнэт цаасны компанийг 2017 оны гишүүнчлэлийн жилийн хураамжаас тус бүр 10 хувийн хөнгөлөлт эдлүүлэхээр боллоо.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АНХНЫ АРИЛЖАА ХИЙГДСЭН ӨДӨР БУЮУ “ДИЛЕРҮҮДИЙН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Монгол улсад хөрөнгийн зах зээлийн анхны арилжаа хийгдсэн өдөр буюу “Дилерүүдийн өдөр”-ийг тохиолдуулан Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны удирдлагууд болон брокер, дилерүүдийн төлөөлөл МХБ-ийн 5408 дахь арилжааг нээж цан цохиллоо.

Энэхүү өдрийг тохиолдуулан зарим гишүүн үнэт цаасны компаниудын удирдлага болон брокер, дилерүүдийг “Хөрөнгийн зах зээлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагналаа.

“ДЭҮ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК” ХХК ОНООСОН НЭРЭЭ “МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК” ХХК БОЛГОН ӨӨРЧИЛЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 оны 1 дүгээр сарын 27-ний өдрийн 63 дугаар тушаалаар Монголын хөрөнгийн биржийн гишүүн “Дэү Секьюритис Монгол ҮЦК” ХХК-ийн оноосон нэрийг “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсөн байна.

“ФРОНТИЕР ҮЦК” ХХК-ИЙН АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЛОО

Монголын хөрөнгийн биржийн гишүүн “Фронтинер ҮЦК” ХХК нь брокер, дилер, андеррайтерын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 3 сарын 10-ны өдрийн 47 тоот тогтоолоор андеррайтерын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Өнөөдрийн байдлаар Үнэт цаас гаргагчдыг Хөрөнгийн зах зээлд зуучлах чиг үүрэг бүхий андеррайтерын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй 24 компани МХБ-д гишүүнчлэлтэй байна.

ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДАД ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙЛЭЭ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталсан удирдамжийн дагуу 2017 оны 04 дүгээр сарын 10-ний өдрөөс эхлэн гишүүн үнэт цаасны компаниудад газар дээрх хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Удирдамжийг гишүүн компаниудад 2017 оны 04-дүгээр сарын 06-ний өдөр хүргүүлсэн ба энэхүү ажлын зорилго нь гишүүн үнэт цаасны компаниудын чадавхыг үнэлж, цаашид хамтарч хэрэгжүүлэх ажлын чиг хандлагыг тодорхойлох зорилготой юм.

“ГОЛОМТ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХХК ОНООСОН НЭРЭЭ ӨӨРЧИЛЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ны даргын 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 330 тоот тушаалаар “Голомт секьюритиз ҮЦК” ХХК-ийн оноосон нэрийг “Голомт капитал ҮЦК” ХХК болгон өөрчлөлт оруулсан байна.



ЗАРИМ ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЛЭЭ

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, ҮЦЗЗТХ-ийн 29.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрийн тухай хуулийн 10.1.4, СЗХ-ны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэн тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-ын 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн нэр бүхий 8 үнэт цаасны компанийн үнэт цаасны зах зээлд зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртлэх хугацаагаар түдгэлзүүлэхээр болсон байна. Үүнд:

Д/Д	Гишүүн компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	"Бага хээр ҮЦК" ХХК	Брокер дилер
2	"Догсон ҮЦК" ХХК	Брокер дилер
3	"Превалент ҮЦК" ХХК	Брокер дилер. Андеррайтер
4	"Финанс линк групп ҮЦК" ХХК	Брокер дилер
5	"Говийн ноён нуруу ҮЦК" ХХК	Брокер дилер
6	"Би Би Эс ЭС ҮЦК" ХХК	Брокер дилер
7	"Зюс капитал ҮЦК" ХХК	Брокер дилер. Хөрөнгө оруулалтын зөвлөх
8	"Эм Даблю Ти Эс ҮЦК" ХХК	Брокер дилер

"АЗИА ПАСИФИК СЕКЬЮРИТИС ҮЦК" ХХК- ИЙН АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЛОО

Монголын хөрөнгийн биржийн гишүүн "Азия Пасифик секьюритис ҮЦК" ХХК нь брокер, дилер, андеррайтерын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 2 сарын 08-ны өдрийн 35 тоот тогтоолоор андеррайтерын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

"МОН НАБ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСЫГ АНГИЛАЛ БУУРУУЛАХААР БОЛЛОО

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.9, 8.10.11, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 21 дүгээр зүйлийн 21.2, 21.4.1, "Мон наб" ХК-ийн 17/03 тоот ангилал бууруулах тухай хүсэлтийг үндэслэн "Мон наб" ХК-ийн үнэт цаасыг II ангиллаас бууруулан "III" ангилалд бүртгэхээр боллоо.



Ногдол ашгийн мэдээ

№	Компанийн нэр	Симбол	Шийдвэр огноо	Бүртгэх өдөр	Тараах өдөр	Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ	Нийт ногдол ашиг
1	Гутал ХК	GTL	17.03.10	17.03.30	2017.08.01-ний өдрөөс	3175	5,139,321,700
2	Таван толгой ХК	TTL	17.04.26	17.03.13	тодорхойгүй	872	45,924,054,400
3	Барилга корпораци ХК	BRC	17.04.15	17.03.16	17.04.15	700	28,463,400
4	Тээвэр дархан ХК	TEE	17.02.17	17.04.07	2017-12-01-ний дотор	500	81,674,500
5	Талх чихэр ХК	TCK	17.03.16	17.03.25	2017-07-01-ний өдрөөс эхлэн олгоно	150	153,555,450
6	Жуулчин дюти фрий ХК	SUL	17.03.17	17.03.28	2017-05-01-ний өдрөөс эхлэн олгоно.	5,000	326,810,000
7	Мик холдинг ХК	MIK	17.03.16	17.04.05	2017-05-05-ны өдрөөс эхлэн олгоно	471.6	9,766,515,312
8	Атар-Өргөө ХК	ATR	17.02.22	17.03.13	2017-05-30-ны өдрөөс эхлэн олгоно	300	52,240,800
9	Ган хийц ХК	GHC	17.02.17	17.03.09	тодорхойгүй	100	24,246,400
10	Зоос гоёл ХК	ZOO	17.02.13	17.04.06	2017.05.01-ний өдрөөс	6000	78,228,000
11	Ариг гал ХК	EER	17.02.20	17.03.31	Тодорхойгүй	17.8224	62,009,800
12	Баянтээг ХК	BTG	17.02.13	17.04.03	2017.06.01-ний өдрөөс эхлэн олгоно	100	25,260,800
13	Монгол алт ХК	ERS	17.02.17	17.04.07	2017.12.01-ний дотор	150	39,877,800
14	Монгол шуудан ХК	MNP	17.02.14	17.04.05	2017-05-01-ний өдрөөс эхлэн олгоно.	3.0323	301,976,370
15	Махимпекс ХК	MMX	17.02.15	17.04.05	2017-10-01-ний өдрөөс эхлэн олгоно.	100	380,072,100
16	Хүрд ХК	HRD	17.02.16	17.02.15	2017-06-30-ны дотор	755	102,125,830
17	Материалимпекс ХК	MIE	17.02.13	17.03.27	2017-12-31-ны дотор	18	24,627,708
18	Адуун чулуун ХК	ADL	17.03.03	17.03.24	2017-06-30-ны дотор	120	378,156,480
19	АПУ ХК	APU	17.02.17	17.03.09	2017.05.30-ны дотор	1	742,877,000
20	Улаанбаатар хивс ХК	UBH	17.02.22	17.03.10	2017.05.15-ны дотор	75	30,362,175
21	Баянгол зочид буудал ХК	BNG	17.02.17	17.03.31	2017.09.01-ний өдрөөс эхлэн	355	150,188,075
22	Говь ХК	GOV	17.02.10	17.03.22	2017.04.20-ны өдрөөс эхлэн	200	1,560,225,000
23	Тахь-ко ХК	TAH	17.02.09	17.03.30	2017.05.01-ний дотор	108	128,518,164
24	Гермес центр ХК	HRM	17.01.31	17.02.22	2017.03.06-ны өдрөөс эхлэн олгоно.	4.07	319,670,014

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN